

“МАНДАЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн шинэчилсэн дүрмийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1, 67-р зүйлийн 67.3.8, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.8 болон Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ын 2-р зүйлийн 2.12, Мандал Даатгал ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.7.1, 2018 оны 12 сарын 12-ний өдрийн ээлжит бус хурлын тооллогын комиссоос баталсан санал хураалтын үр дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мандал Даатгал ХК-ийн шинэчилсэн дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Мандал Даатгал ХК-ийн шинэчилсэн дүрмийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийг бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Мандал Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал (Б.Жавхлан)-д даалгасугай
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, шийдвэрийг нэн даруй нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж-д холбогдох баримт бичиг, мэдээллийг хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлан)-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



Ө.ГАНЗОРИГ